



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№54 /498/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.04.03

Цаг үе, үйл явдал

БАЙЛДАГЧ НАР “СОЁМБОТ” ХАЙРХНЫ ӨДРИЙГ СОЛЪЧХООД ГҮЙГЭЭД ИРЭВ



Дэлхийн аваргын дэд байрын шагналт “Moon dance” бүжгийн хамтлагийнхан амралтын өдрүүдэд нийгмийн сүлжээнд цэргийн алба хаагчдын талаар нэгэн эерэг давлагаа явуулав.

Тэд Өвөрхангай аймагт томилолтоор ажиллахдаа “Энэ уулын тоо өнөөдрийн он, сар, өдрөөрөө байх юм. Өдөр болгон сольдог хэрэг үү. Цэргүүдээрээ бахархаж байна” гэсэн нь олны дэмжлэгийг ихэд авч, он, сарыг нь сольж байсан түрүүч, байлдагч нарын сайхан дурсамжаар булагдсан байв.

Өдөр бүр солигддог “Цорцой” буюу цэргийнхний хэлж заншсанаар “Соёмбот” хайрхны он, сар, өдрийг 4 дүгээр сарын 3-ны энэ өдөр Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч О.Бат-Эрдэнэ, Б.Отгондолгор нар хуваарийн дагуу өглөө эртлэн босоод солчхоод иржээ.

Тэдний хувьд цэргийн албанд татагдан ирснээс хойш 6 дахь удаагаа сольсон бөгөөд хугацаат цэргийн алба хаагчдын хамгийн дуртай үүрэгт ажлын нэг нь энэ гэнэ. Гимнастик, дасгал сургалт болдог, нөгөө талаар хайрхан дээр өглөөний ургах нарыг угтдаг нь сэтгэл санаа өргөхөөс эхлээд олон талын ач холбогдолтой байна. Хамгийн

гол нь баруун аймаг болон нийслэлийг зорьж яваа тээвэрчдэд замч болж, он сар, өдрийг нь “сануулдаг” байна.

Өнөө өглөөний “Соёмбот” хайрхны өдрийг сольсон байлдагчийн нэг О.Бат-Эрдэнэ нь Архангай аймгийн Ихтамир сумынх. Дөрвөн хүүтэй айлын дундах нь. Аав Д.Одгэрэл, ээж О.Өрнөхжаргал нь нутагтаа малаа маллан амьдран сууж, том ах нь БНСУ-д ажиллаж, хоёр бага дүү нь сумынхаа сургуульд суралцдаг байна.

Тэрээр 2017-2020 онд Техник Технологийн Политехник коллежийг хоол зүйч мэргэжлээр төгсөж, “Чингисийн хүрээ” амралтын газар тогоочоор ажиллаж байгаад цэргийн албанд хүсэл мөрөөдлөөрөө иржээ. Зураг зурах авьяастай. Сурагч, оюутан байхдаа уран зургаараа олон уралдаан тэмцээнд оролцож явсан авьяаслаг байлдагч маань цэргийн алба хаангаа солонгос, англи хэл суралцаж яваа гэнэ. “Нэг нэгнээсээ” гэсэн зарчмаар танкийн тусгай хорооныхон цэргийн сургалт бэлтгэлийн бус цагаар нэгэндээ хичээл явуулдаг ба үүний нэг нь хэлний мэдлэгийг нь дээшлүүлэх зорилтот ажил ажээ.

Харин түүний нөгөөх байлдагч Б.Отгондолгор нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий

сумынх. “Монгол цэргийн өдөр”-өөр Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театрын тайзнаа уншигдсан “Тэнгэрт байгаа аавдаа” шүлгийн эзэн. Шүлэг, яруу найрагт дуртай тэрээр цэрэгт ирээд “эр цэрэг болох, аав шигээ эр хүн байх” тухай өгүүлэмжээр шүлэг тэрлэсэн нь Өвөрхангай аймагтаа тэргүүлж, мэргэжлийн жүжигчид тайзнаа уншин сонордуулсан нь үзэгчдийн талархлыг ихэд хүлээсэн билээ.

Байлдагч Б.Отгондолгорын зорилго офицер болох бөгөөд эхний ээлжид ангидаа цэргийн гэрээт алба хаагчаар улирахаар төлөвлөжээ. Цэргийн албанаас авсан хүмүүжил, төлөвшил нь түүнийг энэ зам руу хөтөлж байгааг онцолж, он, сар солихдоо тэдний онжавууд үргэлж дуртай байдаг, өрлөг хийхэд ердөө 5-хан минут л болдог гэж байв.

Ташрамд онцлоход, “Соёмбот” хайрхны он, сар, өдрийг 1988 оноос хойш өдөр бүр тасралтгүй сольж байгаа бөгөөд 2020 онд тоо бичигдэх зайг төмрөөр зангидаж, өрлөг хийхэд илүү хялбар болгосон байна. Он солилгодоход салаагаараа, өдөр тутамдаа хоёр хугацаат цэргийн алба хаагч хуваарийн дагуу сольж, тээвэрчдэд замч хийсээр байгаа нь энэ билээ.

Ахмад Д.БОЛОР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-16

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41	26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,513	3,518
EUR	3,810	3,830
CNY	510	514
RUB	44.80	45.40
JPY	26.50	26.80
KRW	2.71	2.73

ЗУРХАЙ



2023.04.03 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 13

**ХАВРЫН ДУНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.27-19.24

БАРИЛДЛАГА:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Төрөн түгэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, хувцасхийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олодох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГТГЭЛ, АНГИУДАД СЭТГЭЛ ЗҮЙН БҮЛЭГ АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчинд алба хааж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний зарим нэгтгэл, ангиудад “Сэтгэл зүйн бүлэг” үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Тодруулбал, уг бүлэг энэ удаа Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын дунд сургалт, оношилгоо, зөвлөгөөний ажлыг зохион байгуулж, тэдний сэтгэл зүйн онцлогуудыг илрүүлэх багц оношилгоог авсан ба хувь хүн, алба, тасаг, салбар, ангийн

хэмжээнд үр дүнг боловсруулан, цаг тухайд нь танилцуулан ажиллалаа.

Сургалтын эхэнд оролцогчдын дунд сургалтад анхаарлаа хандуулах, эерэг уур амьсгалыг бий болгох, өөрийнхөөрөө чөлөөтэй оролцох боломжийг нь бүрдүүлэх зорилгоор нүүр хагарах хичээлийг явуулсан нь үр дүнгээ өгч, тэдний идэвх оролцоо эрс нэмэгдсэн юм. Үргэлжлүүлэн хувь хүний чадваруудыг илрүүлэх “Хамт олны сэтгэл зүй”, “Харилцааны сэтгэл зүй”, “EQ”, “Зөрчил маргааны сэтгэл зүй”, “Цаг ашиглах чадварын сэтгэл зүй” зэрэг 5 төрлийн оношилгоо хичээлийг зохион байгуулж, хичээлийн төгсгөл бүрт оношилгооны тайлал, таниулах сургалт, дасгал ажлыг

явуулан, өөрийгөө таньж мэдэх, сул болон давуу чанаруудаа ойлгох, цаашид өөрийгөө хөгжүүлэхэд аль асуудалд түлхүү анхаарах тал дээр заавар, зөвлөгөө өгч ажилласан нь тэдний талархлыг хүлээв.

Мөн тус ангийн бие бүрэлдэхүүнтэй сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөнийг “Стрессээ таньж мэдэх нь”, “Өөрийгөө таньж мэдэх нь” зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг нийт 6 цэргийн алба хаагчдад өгсөн юм. Энэ үеэр сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдах хүсэлтэй алба хаагчид олон байсан ба өөрт тулгарсан асуудалгүй алба хаагчид сонирхолдоо хөтлөгдөн ирж байлаа.

Сургалтын төгсгөлд хугацаат цэргийн алба хаагчдад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх

“Монгол бахархал”, “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдвээр сонирхолтой яриа, хэлэлцүүлгийг зохион явуулж тэдний алба хаах урам зориг, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэв.

“Сэтгэл зүйн бүлэг”-ийн зорилго нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг сорил, судалгаа, оношилгоо, сургалт, дадлагын тусламжтайгаар илрүүлж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох, сэтгэл зүйн хямрал, гутралд орсон, сэтгэл зүйн туслалцаа шаардлагатай цэргийн алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тренинг зохион байгуулах, цэргийн сэтгэл зүйчдийн үйл ажиллагааг шалган туслахад чиглэгдэж байгаа талаар ахмад Б.Жавхлантөгс мэдээлэв.

Хурандаа Б.ОТГОНБЯЯ



**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 684,083,976

Эдгэрсэн

Нийт: 6,832,265

Нас барсан

Нийт: 6,832,265

Цахим шууданд

ТӨРИЙН ХҮНДЭТ ХАРУУЛ ДИПЛОМАТ ЁСЛОЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ



Бруней Даруссалам Улс, Бүгд Найрамдах Эль Сальвадор Улс, Бахрейны Хаант Улс зэрэг 22 улсаас манай улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид итгэмжлэх жуух бичгээ өргөн барих ёслолын ажиллагаанд Монгол Улсын Төрийн хүндэт харуулын бүрэлдэхүүн амжилттай үүргээ гүйцэтгэлээ.

Тус ёслолын ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар батлагдсан "Төрийн ёслолын журам"-ийн "Дипломат ёслол"-ийн 32 дугаар

зүйлд заасны дагуу Төрийн хүндэт харуул жагсаж хүлээн авлаа.

Энэхүү ёслолын үйл ажиллагаа нь Төрийн хүндэт харуулын 68 жилийн түүхийн хугацаан дахь нэг өдөр зохион байгуулагдсан хамгийн олон Төрийн ёслолын үйл ажиллагаа болсноороо онцлог байлаа.

НАЛАЙХ ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ СПОРТЫН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



"Монгол цэргийн өдөр" орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тохиолдуулан Налайх цэргийн хүрээний Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулсан Налайх дүүргийн Засаг даргын нэрэмжит "Спортын цогцолбор тэмцээн"-д Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн баг тамирчид спортын 4 төрлөөр хурд хүч, тэсвэр хатуужил, авхаалж самбаагаа дайчлан амжилттай оролцож, багийн дүнгээр II дугаар байрт шалгарлаа.

"НЭГ НУТГИЙН УУЛЗАЛТ ӨДӨРЛӨГ"-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



зэрэгцээ гарын бэлэг, ар гэрийн захиа, илгээмжийг хүлээлгэн өглөө.

Арга хэмжээний төгсгөлд хугацаат цэргийн албаа нэр төртэй хааж байгаа дайчдадаа Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж, Цэргийн штабын дарга хурандаа М.Дэлгэрсайхан нар цэргийн албанд нь баяр хүргэж амжилт хүссэн юм.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цэргийн штабын 2023 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймгаас 2022 оны нэг, хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Хилийн цэргийн 0131 дүгээр ангид алба хааж байгаа дайчдад хүндэтгэл үзүүлэх ажиллагааг зохион байгууллаа.

Хугацаат цэргийн алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд Өвөрхангай аймгийн Засаг

дарга А.Ишдорж, Цэргийн штабын дарга хурандаа М.Дэлгэрсайхан, Тоо бүртгэлийн ахлах офицердэд хурандаа Ч.Ванчинсүрэн, 11 сумын ЗДТГ-ын дарга нар оролцлоо

Өдөрлөгийн хүрээнд Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Хилийн цэргийн 0131 дүгээр анги болон хилийн 2,3,4 дүгээр заставын үйл ажиллагаа, хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын орчин нөхцөлтэй танилцаж, нэгдсэн золголтыг зохион байгуулж, аймаг орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтын талаар танилцуулга хийсний



МАРШ ҮЙЛДЭХ ҮЕЭРЭЭ БАЙГАЛЬ ОРЧНОО ЦЭВЭРЛЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 341 дүгээр анги 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн байнгын бие бүрэлдэхүүний бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нэмэгдүүлэх зорилгоор 30км-ийн явган маршийг үйлдэв.

Маршийг Хонхор өртөөнөөс Богд хан уулын Цэцээ гүн оргил гэсэн маршрутаар үйлдсэн бөгөөд энэ үеэр нийгмийн хариуцлагын хүрээнд Цэцээ гүн оргил орчим болон маршрутын дагуух хог хаягдлыг бүхэлд нь цэвэрлэж аялагчдын ая тухтай аялах орчин нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Ахлах дэслэгч Г.ТҮМЭНБАЯР



ЭЭРЭГ



Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн бие бүрэлдэхүүн Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, уялдаа холбоог хангах зорилгоор Нийслэлийн "Налайх" дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт цаг

уурын хүндэрсэн нөхцөл байдлын улмаас цасанд боогдсон 1 километр үргэлжлэх авто замын цасыг цэвэрлэж дүүргийн болон хорооны иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлжээ.

